Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Эрүүл мэндийн яамнаас 15.7 сая төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас 121.3 сая төгрөг, Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооноос 1,9 сая төгрөг, Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс 36.7 сая төгрөг, Нэгдсэн үндэстний байгууллагын Хүүхдийн сангаас 92.6 сая төгрөг, Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтыг зохицуулах газраас 70.0 мянган төгрөг, Төрийн өмч, бодлого зохицуулалтын газраас 1,1 сая төгрөг нийт 269.3 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зориулалтын дагуу зарцуулагдсан байна.

- Эрүүл мэндийн яамнаас санхүүжүүлсэн 15.7 сая төгрөгийг Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/177 дугаар тушаалаар “Цахим эрүүл мэнд” сургалтад 13.3 сая төгрөгийг мөн аймгийн Нийгмийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 2.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

- Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс хуваариласан 3.3 сая төгрөгийг хүний папилома вирусын халдварын эсрэг вакциныг нэвтрүүлэх бэлтгэх ажлыг хангах хүрээнд сум, өрхийн эрүүл мэндийн төвд сургалт, мэдээлэл хийж, дэмжлэгт хяналт үнэлгээ хийсэн байна.

-Мөн 33.4 сая төгрөгийг Хүний папилома вирусын эсрэг вакциныг улсын хэмжээнд нэвтрүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээний боловсролын байгууллагуудын удирдлага, сургуулийн эмч нар болон сумын эрүүл мэндийн төвийн удирдлага, их эмч, вакциinator зэрэг нийт 64 хүнд сургалт зохион байгуулахад зарцуулсан байна.

- Орон нутгийн төсвөөс ажилчдад олгох орон нутгийн нэмэгдэлд 116.4 сая төгрөгийн, Хүүхдийн өвчний цогц менежмент болон Нярайн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд лавлагаа шатлалын нарийн мэргэжлийн эмчээр орон нутгийн эмч нарын ур чадвар, мэдлэгийг сайжруулах ажлын байрны 2 сургалтад 4.5 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч зарцуулсан байна.

- НҮБ-ын Хүүхдийн сангаас ирсэн 92.6 сая төгрөгт “Олон нийтэд түшиглэсэн нялхас, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх сургалт”-ыг аймгийн Нэгдсэн эмнэлэг, сумын болон өрхийн эмч нарт 2 удаа, мөн Спрептококкийн халдварын Үндэсний сургагч багш бэлтгэх сургалт болон эцэг эхийн сургалтуудыг зохион байгуулж, Улаанбаатар хотоос багш урьж хичээл заалгаж, замын зардал, томилолт, хичээл заасны хөлс болон сумын эрүүл мэндийн төвөөс оролцогчдын томилолт, шатахууны зардлыг олгосон байна.

- Сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооноос ирсэн 1.9 сая төгрөгийг зарим сумын эрүүл мэндийн төвүүдэд сүрьеэгийн тусламж үйлчилгээнд дэмжлэгт хяналт хийгдсэн байна.

- Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналтыг зохицуулах газраас ирсэн 0.07 сая төгрөгийг шатахууны зардалд шилжүүлсэн байна.

- Төрийн өмч, бодлого зохицуулалтын газраас ирсэн 1.1 сая төгрөгийг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах тендер зохион байгуулах бичиг хэрэг худалдан авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж



Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

заасны дагуу аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор Ж.Айгүл нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн 43 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 4,258.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 85.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд алдаа зөрчил илрээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансанд цалингийн орлогоос бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 90,962.7 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэрийн 15,092.8 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй, бүгд 106,055.5 мянган төгрөгийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илээгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар тусгай зориулалтын материал дансанд бүртгэлтэй хугацаа дууссан эмийн бүртгэлтэй холбоотой асуудлыг анхаарах. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж санхүүжилтийн зарцуулалт, орон тоотой холбоотой асуудлыг бүрэн шалгах боломжгүй байсан болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 150.4 сая төгрөгийн зөрчил илэрч 6.4 сая төгрөгийн 2 төлөрийн акт, 37.9 сая төгрөгийн 2 албан шаардлага, 106.1 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар нийт 6,358.4 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

1.Аймгийн Эрүүл мэндийн газрын даргад мөнгөн урамшуулал олгох талаар дээд шатны төсвийн захирагчаас эрх зүйн акт, тушаал шийдвэр гараагүй байхад 1,449.7 төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс холбогдох хууль, журам зөрчиж олгосон 1,449.7 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх акт тогтоов.

2.Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 6 албан хаагчид 49,087,246 төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 4,908,725 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно", 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.",



Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д “Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно”, 6.3.1-д “цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого”, 21-р зүйлийн 21.1-д “Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна”, 25 дугаар зүйлийн 25.1-д “Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална”, 25.1.1-д “энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвөөс холбогдох хууль, журам зөрчиж олгосон 4,908.7 мянган төгрөгийг нөхөн төлүүлэх акт тогтоов.

## 5.2 Албан шаардлага

Аудитаар 37,940.4 мянган төгрөгийн албан шаардлага өгсөн.

1.Монгол Улсын Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 6 дугаар сарын 26-ний өдөр төсвийн шууд захирагч, төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшуулал олгох тухай 2/2782 дугаар албан тоотыг үндэслэн Эрүүл мэндийн газрын даргад, Эрүүл мэндийн газрын газрын даргын 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн Б/26 дугаар тушаалаар ерөнхий нягтлан бодогч, нярав нарт, 2024 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн Б/45 дугаар тушаалаар эдийн засагч нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар “Өөрчлөлтгүй дүгнэлт” авсан гэж нийтдээ 9,633.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 3.2-т “Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн” үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх.

1.Баян-Өлгий аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 130/ШШ2023/01078 дугаар шийдвэрээр М.Еркебуланд ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговорт 19,157.2 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 253.7 мянган төгрөг нийтдээ 19,440,940 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн.

2.Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн 130/ШШ2024/00184 дугаар шийдвэрээр У.Есентайд ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговорт 8,766,468 төгрөгийг, улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70.2 мянган төгрөг, ажиллагааны зардалд 30.0 мянган төгрөг нийтдээ 8,866,468 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байна.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 04 дугаар сарын 11-ний өдрийн 01/421, 01/427 дугаар албан бичгийн дагуу М.Еркебулан, У.Есентай нарт олгосон нийт 28,307,408 төгрөгийн нөхөн олговрыг аймгийн Эрүүл мэндийн газрын төсвөөс аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Төрийн банк нь дахь 29140002230 тоот дансанд шилжүүлж, төсвөөс зориулалт бус зардал гаргаж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна

Шийдвэрлэсэн нь: Төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, хохиролгүй болгох арга хэмжээ авах.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой асуудал

**1.1. Илрүүлэлт:** Бараа материалын тусгай зориулалтын материал дансанд бүртгэлтэй нэг бүрийн үнэ нь 37,037 төгрөгийн 9095 ширхэг нийтдээ 336,851.5 мянган төгрөгийн 2023 оны 04-р сарын 16-ны өдрөөр ашиглах хугацаа нь дууссан Ковид-19 эсрэг вакцины акталж данснаас хасах асуудлыг шийдвэрлээгүй байна.

Энэ нь Төрийн болон өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1-д “төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй, санхүүгийн тайлангийн толилуулга, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:** Бараа материалын тусгай зориулалтын материал дансанд бүртгэлтэй дээрх эмийг өмч хамгаалах зөвлөлөөр дүгнэлт гаргуулж холбогдох газруудад актлах санал хүргүүлэн, данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах.

#### 2. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал

**2.1. Илрүүлэлт:** Шилэн дансанд цалингийн орлогоос бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 90,962.7 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 10 шийдвэрийн 15,092.8 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй, бүгд 106,055.5 мянган төгрөгийг тус тус дутуу мэдээлсэн ба шилэн дансны хэрэгжилт 85 хувьтай байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:** Шилэн дансанд цалингийн орлогоос бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 90,962.7 мянган төгрөгийн мөнгөн гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэрийн 15,092.8 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй, бүгд 106,055.5 мянган төгрөгийг нөхөж байршуулан зөрчлийг арилгах, Шилэн дансны хуулийг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн дотор Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул аагүй		Тоо	Дүн
<b>Дүн</b>												

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

		/мянган төгрөгөөр/	
Нийт зөрчил		Үүнээс	



Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Зөрчлийн товч утга	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус газрын даргад тушаал шийдвэргүй урамшуулал олгосон	1	1,449.7	1	1,449.7						
5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын олгохдоо 4,908,725 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон	1	4,908.7	1	4,908.7						
Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.	1	9,633.0			1	9,633.0				
Төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна	1	28,307.4			1	28,307.4				
Ашиглах хугацаа нь дууссан Ковид-19 эсрэг вакцины акталж данснаас хасаагүй	1	0					1	0		
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>44,298.8</b>	<b>1</b>	<b>6,358.4</b>	<b>1</b>	<b>37,940.4</b>		<b>0</b>		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
5 саяаас дээш орлогын гүйлгээ, Төсөв, өмч, хөрөнгө зарцуулсан шийдвэрийг тус	1	106,055.5						1	106,055.5

Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

тус дутуу байршуулсан								
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>106,055.5</b>					<b>1</b>	<b>106,055.5</b>
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>106,055.5</b>					<b>1</b>	<b>106,055.5</b>





**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Х.АНЖЕЛИКА ТАНАА**

2025.02.14 № 40  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тусгай зориулалтын материал дансанд нэг бүрийн үнэ нь 37,037 төгрөгийн 9095 ширхэг нийтдээ 336.8 сая төгрөгийн 2023 оны 04 дүгээр сарын 16-ны өдрөөр ашиглах хугацаа нь дууссан Ковид-19 өвчний эсрэг вакцин бүртгэлтэй байгаа ба акталж данснаас хасах асуудлыг шийдвэрлээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

832502000020

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ





БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АКТ

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 05/БГА-2025/008/КА-СА-ТЧЗ

Өлгий

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар цалин, нэмэгдлийн тооцоог шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга нь 2024 оны 12 дугаар сард эрх бүхий байгууллагуудаас газрын даргад урамшуулал олгох тухай шийдвэр гараагүй байхад төсвөөс 1,449,700 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг дур мэдэн хууль бус авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн 41.2.3-т "төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төсвөөс холбогдох хууль, журам зөрчиж олгосон 1,449.700 төгрөгийг аймгийн Эрүүл мэндийн газрын даргаар ажиллаж байсан Н.Сакенээр нөхөн төлүүлж аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь төсвийн орлогын 100020051005 тоот дансанд 2025 оны 10 дугаар сарын 10-ны дотор оруулах;

2. Актын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Анжелика/ ерөнхий нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэгч /О.Айбота/ нарт хариуцуулав.

**АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР



С.НУРЛАН

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ







БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 8/169А - 2025/005/КА-СТА-243

Өлгий

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар төсвийн зарцуулалтыг шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Баян-Өлгий аймаг дахь Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн 130/ШШ2023/01078 дугаар шийдвэрээр М.Еркебуланд ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговорт 19,157.2 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 253.7 мянган төгрөг нийтдээ 19,440,940 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн.

2. Сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 02 дугаар сарын 20-ний өдрийн 130/ШШ2024/00184 дугаар шийдвэрээр У.Есентайд ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговорт 8,766,468 төгрөгийг, улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70.2 мянган төгрөг, ажиллагааны зардалд 30.0 мянган төгрөг нийтдээ 8,866,468 төгрөгийг олгохоор шийдвэрлэсэн байна.

Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2024 оны 04 дугаар сарын 11-ний өдрийн 01/427, 01/421 дугаар албан бичгийн дагуу М.Еркебулан, У.Есентай нарт олгосон нийт 28,307,408 төгрөгийн нөхөн олговрыг аймгийн Эрүүл мэндийн газрын төсвөөс аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Төрийн банк нь дахь 29140002230 тоот дансанд шилжүүлж, төсвөөс зориулалт бус зардал гаргаж, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна", Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д "Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар

хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.6-д “төсвийг зориулалт бусаар зарцуулсан” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Иргэн М.Еркебулан болон У.Есентай нарт ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт төсвөөс төлсөн 28,307,408 төгрөгийг буруутай шийдвэр гаргаж төрд хохирол учруулсан аймгийн Эрүүл мэндийн газрын даргаар ажиллаж байсан Н.Сакенээр нөхөн төлүүлж, Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь төсвийн орлогын 100020051005 тоот дансанд 2025 оны 12 дугаар сарын 01-ны дотор оруулах;

2.Албан шаардлагын биелэлтийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 12 дугаар сарын 01-ны дотор ирүүлэх;

3.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, албан шаардлагын биелэлтийг хангаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Дауиржан/, нягтлан бодогчийн ажлыг түр хавсран гүйцэтгэгч /О.Айбота/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР




С.НУРЛАН

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ







БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АКТ

2025 оны 02 сарын 28 өдөр

Дугаар 35/БГА-2025/008/КА-СГА-1443

Өлгий

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар нэг удаагийн мөнгөн урамшууллын тооцоог шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Аймгийн Эрүүл мэндийн газар нь 2024 онд хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллын тооцоогоор 6 албан хаагчид 49,087,246 төгрөгийн мөнгөн урамшуулал олгохдоо 4,908,725 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар суутгаагүй олгосон байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Татварын хууль тогтоомжид хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно", 6.1.19-д "суутган төлөгч" гэж тухайн төрлийн татварын хуулийн дагуу татвар төлөгчийн төлөх татварыг суутгаж, төсөвт шилжүүлэх, тайлагнах үүрэг бүхий этгээдийг", 28 дугаар зүйлийн 28.7-д "Суутган төлөгч нь татварын хууль тогтоомжийн дагуу тухайн төрлийн татвар төлөх үүрэг бүхий этгээдээс албан татварыг ногдуулан суутгана.",

Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д "Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно", 6.3.1-д "цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого", 21-р зүйлийн 21.1-д "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасны дагуу тухайн жилийн орлогыг тодорхойлоход 0-120 000 000 хүртэлх төгрөгийн албан татвар ногдуулах орлого олсон тохиолдолд 10 хувиар,..... тооцон албан татвар ногдуулна", 25 дугаар зүйлийн 25.1-д "Энэ хуулийн 4.1.11-д заасан суутган төлөгч албан татвар ногдуулахад доор дурдсан журмыг баримтална", 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар

баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн захиргааны албан хаагчдад 5 жил тутам нэг удаа олгох мөнгөн урамшууллаас суутгаагүй 4,908,725 төгрөгийн хувь хүний орлогын албан татварыг хавсралтад заасан нэр бүхий албан хаагчдаар нөхөн төлүүлэх;

2. Төлбөрийн актыг төсвийн орлого болгож аймаг дахь Төрийн аудитын газрын Төрийн сан дахь 100020051005 тоот дансанд 2025 оны 10 дугаар сарын 30-ны дотор барагдуулах;

3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Дауыржан/, нягтлан бодогчийн ажлыг түр хавсран гүйцэтгэгч /О.Айбота/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТОР

С.НУРЛАН

БАТАЛГААЖУУЛСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.АЙГҮЛ



<sup>1</sup> Баян-Өлгий аймаг, Өлгий сум, 5 дугаар баг, ЗДТГ-ын байр 1 дүгээр давхар. Утас: 70422954, 70422930



Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын  
газрын 2025 оны 2-р сарын ...-ны өдрийн  
... дугаар актын хавсралт

8317144071  
БЮА0074 9007245

№	Ажиллагсдын нэрс	Мөнгөн урамшууллын дүн	Суутган төлөх татварын мөнгөн дүн
1	Б.НУРЖАЙНАР	6,555,768	655,577
2	О.ЛХАГВАЖАВ	8,632,326	863,233
3	Н.САКЕН	10,383,828	1,038,383
4	Б.ГУЛБАНУ	8,118,000	811,800
5	Х.СВЕТА	6,765,000	676,500
6	М.РУСТЕМ	8,632,324	863,232
<b>Нийт дүн</b>		<b>49,087,246</b>	<b>4,908,725</b>

Хавсралт гаргасан: Аудитор



С.Нурлан



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 22/БГА-2025/005/НА-ӨТА-ТШЗ

Өлгий

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газрын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн баталгаажуулах аудитаар цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын тооцоог шалгаж үзэхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Монгол Улсын Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 6 дугаар сарын 26-ний өдөр төсвийн шууд захирагч, төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшуулал олгох тухай 2/2782 дугаар албан тоотыг үндэслэн Эрүүл мэндийн газрын даргад, Эрүүл мэндийн газрын газрын даргын 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн Б/26 дугаар тушаалаар ерөнхий нягтлан бодогч, нярав нарт, 2024 оны 12 дугаар сарын 02-ний өдрийн Б/45 дугаар тушаалаар эдийн засагч нарт 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар "Өөрчлөлтгүй дүгнэлт" авсан гэж нийтдээ 9,633.0 мянган төгрөгийн урамшуулал олгож, төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын хэмжээг хэтрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 3.2-т "Улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийг үндэслэн" үндсэн цалингийн 10-20 хувиар сар бүр тооцож, улирал тутам олгоно гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан



зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.4-т “төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллыг холбогдох хууль, журам зөрчиж тогтоосон хэмжээнээс хэтрүүлэн олгохгүй байх;
2. Зөрчлийг арилгаж албан шаардлагын биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 10-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Анжелика/, ерөнхий нягтлан бодогчийн ажлыг хавсран гүйцэтгэгч /О.Айбота/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР



С.НУРЛАН

**БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.АЙГҮЛ

<sup>1</sup> Баян-Өлгий аймаг. Өлгий сум. 5 дугаар баг. ЗДТГ-ын байр 1 дүгээр давхар. Утас: 70422954, 70422930